



Хаяг: МТУПарк (Өргөө2),  
3 давхар, 307 тоот, Best төв

## УУЛЗАЛТ ӨДӨРЛӨГ

### Өдөрлөгийн хөтөлбөр:

**14:00** Америкийн их сургуулиудын танилцуулгууд (АМОХ)

**15:00** Яагаад заавал Америкт суралцах ёстой гэж?  
(Сүхбат — Wesleyan University,  
Цэнгүүн — Cornell University,  
Тулгаа — Brown University)

**15:40** ВUOP хөтөлбөрийн талаар  
(Буяннэмэх — Mount Holyoke Col-  
lege, Жавхлан-Очир — Ohio State  
University)

**16:00** Судлаач оюутан  
(Номинсүрэн — Washington Uni-  
versity in St. Louis)

**16:20** College student  
(Цацрал — Earlham College)  
(Оргил — Albion College)  
(Уянга — Princeton University)  
(Батжин — Williams College)

**16:40 — 17:00**  
Асуулт хариултууд (АМОХ)

### Яагаад заавал Америкт суралцах ёстой гэж?

Өнөөгийн үсрэнгүй хөгжиж буй нийгэм, тэр дундаа сүүлийн жилүүдэд түүнээс ч хурдан хөгжиж буй Монгол орны залуус бид энэхүү хөгжилтэй хөл нийлүүлэн алхах боломж гарч бас шаардлага тулгарч байгаа билээ. Энэ ч үүднээсээ залуус бид гадны хөгжингүй орнуудад боловсрол мэдлэг эзэмшихийг илүүд эрмэлзэх болсон. Тэр дундаа Америкийн их дээд сургуулиуд яах аргагүй дэлхийн тэргүүлэгч боловсролыг оюутан сурагчиддаа олгож чаддаг байна. Тэдгээр сургуулиудад суралцахад Монгол оюутнуудад үүд хаалга нь өргөн нээлттэй байдаг хэдий ч, мэдээ мэдээллийн дутмаг байдлаас болон ихэнх Монгол оюутнууд маань энэхүү боломжийг төдий ашиглаж чадахгүй явсаар иржээ. Энэ зун зохион байгуулагдаж буй энэхүү өдөрлөг болон “Best University Opportunity Program” (ВUOP) нь оюутан залуустаа Америкт оюуныхаа хүчээр тэтгэлэгтэйгээр суралцах боломжийг дэлгэрэнгүй танилцуулах, хэрэгцээтэй шалгалтуудад бэлтгэх цогц хөтөлбөр юм.

### ВUOP хөтөлбөрийн талаар

Америкийн шилдэг их дээд сургуулиудад тэнцсэн Монгол оюутан залуус 2011 оны зун анх удаа ВUOP хөтөлбөрийг бусад Америкт суралцах хүсэлтэй оюутан сурагчдад мэдээлэл хүргэх зорилгоор санаачлан байгуулж байсан билээ. Харин тэдгээр оюутнуудын оролцоотойгоор Америк дахь Монгол Оюутны Холбоо байгуулагдаж энэ удаагийн ВUOP хөтөлбөрийг дахин зохион байгуулж байна.

### ВUOP хөтөлбөрөөр заагдах хичээлүүд:

#### Course for application

Америкт тэтгэлэгтэйгээр суралцахад хэрэгцээтэй бүхий л мэдээллээс гадна сургуулиа хайх өргөдлөө явуулах зэргийг багтаасан.

#### SAT critical reading

Хамгийн гол шалгалт болох SAT - н шүүмжлэн унших хэсэгт бэлдэнэ.

#### SAT writing

SAT-н дараагийн хэсэг болох бичих хэсэгт бэлдэнэ.

#### SAT II - Math

Математикийн шалгалтанд зориулагдаснаас гадна SAT I -ийн Математикийн хэсэгт давхар бэлдэхээрээ онцлог юм.

#### SAT II - Physics

Сонголтот шалгалтуудын Физикийн хэсэгт бэлдэнэ.

#### SAT II - Chemistry

Сонголтот шалгалтуудын бас нэгэн шалгалт болох Химийн шалгалтанд бэлдэхэд зориулагдсан.

#### Pre-Toefl

TOEFL-н шалгалтаа шууд өгөхөд харахан бэлэн биш байгаа бол тус анги нь их тохиромжтой юм.

#### iBT

TOEFL –н шалгалтанд бэлдэхэд чиглэгдсэн эрчимжүүлсэн анги.

#### Course for 8, 9th graders

8, 9-р ангийн хүүхдүүд шууд шалгалтуудаа өгөх эсвэл сургуулиа сонгоход эрт байж болно харин түүнд эртнээс бэлдэж эхлэхэд хэзээ ч оройтохгүй.



Хаяг: МТУПарк (Өргөө2),  
145 тоот, Best төв

### Санах ёстой хугацаанууд:

**11 сар.** Хэрэв та 1-р ээлжээр (early decision) өргөдлөө явуулах гэж байгаа бол энэ сард багтаан iBT, SAT-н шалгалтууд болон эссэ зэрэг бусад материалуудаа бэлэн болгосон байх хэрэгтэй.

**11 сарын 15.** Ихэнхи сургуулиуд 1-р ээлжийн буюу “early decision” өргөдлүүдийг авч дуусдаг.

**12 сар.** Шалгалтуудаа өгч дуусан сургуулиудруугаа оноо болон өргөдлийн бусад материалуудыг явуулж дуусах.

**1 сарын 1.** Ихэнхи сургуулиуд үндсэн ээлжийн (regular decision) “өргөдлүүдийг” хүлээж авч дуусдаг.

**2 сарын 15.** Ихэнхи сургуулиуд санхүүгийн материалуудаа авч дуусдаг.

**3 сарын 23.** Сургуулиудын хариунууд гарч эхэлдэг.

**5 сарын 1.** Тэнцсэн сургуулиуд дундаасаа өөрийн сонгосон сургуулидаа элсэх тухайгаа мэдэгдэж холбогдох бичиг баримтыг илгээх.

### Америк дахь Монгол Оюутны Холбоо

Америк дахь Монгол Оюутны Холбоо (АМОХ) нь Америкийн нэр хүндтэй их дээд сургуулиудад суралцагч Монголын шилдэг оюутан, төгсөгчдийг хамарсан, ашгийн төлөө бус байгууллага бөгөөд гишүүдийг холбосон сүлжээ, тэдгээрийн мэдээллийн санг бий болгож, Монгол улсад болон олон улсад боловсрол, эдийн засаг болон сайн санааны үйл ажиллагаа зохион байгуулж оролцох зорилготой юм. Байгуулагдаад удаагүй байгаа ч тус холбоо нь баклавр, магистр, докторын зэрэгт суралцаж буй 70 гаруй Монгол оюутнуудыгаа нэгтгээд байна.

Цаашид олон арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд 2012 оны өвөл ерөнхий боловсролын 11 сургуулиудын нийт 750 орчим сурагчдад “Америкт хэрхэн тэтгэлэгтэйгээр суралцах боломжтой вэ?” сэдвийн дор илтгэл тавьж хүргэсэн билээ. Энэхүү уулзалт өдөрлөг болон ВUOP хөтөлбөр нь Монголдоо байгаа залуустаа хандсан АМОХ-ны хоёр дахь үйл ажиллагаа болж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд Монголоос Америкт суралцах хүсэлтэй хүүхэд залуусыгаа Америкт суралцаж буй гишүүн оюутнуудтайгаа холбож туршлага солилцох боломжийг бүрдүүлэхээрээ онцлог юм.

**Америкт хүссэн их дээд сургуульдаа оюуныхаа хүчээр тэтгэлэгтэйгээр суралцацгаая!**

### Сургуулиудын мэдээлэл:

Цаашид илүү дэлгэрэнгүй асуух асуултуудыг доор дурдсан цахим хуудсуудаас авч болох бөгөөд сонирхож буй тодорхой нэгэн сургуулийн дэлгэрэнгүй мэдээллийг тухайн сургуулийн цахим хуудаснаас авч болохыг анхаарна уу. Тухайн сургуулийн цахим хуудсыг интернетэд бүтэн нэрийг нь бичиж хайлт хийснээр хялбархан олох боломжтой.

### Өдөрлөгт оролцсон сургуулиуд:

\* Cornell University \* Wesleyan University \* Harvard University \* Ohio State University \* MIT \* Mount Holyoke College \* Purdue University \* State University of Pennsylvania \* Princeton University \* Michigan State University \* Lehigh University \* Cornell College \* Williams College \* Columbia University \* Brown University \* Albion College \* Smith College \* Boston University \* Lindenwood University \* Kenyon College \* University of Minnesota \*

### Дэлгэрэнгүй мэдээллийг:

[www.amsa.mn](http://www.amsa.mn)  
[www.bestcenter.mn](http://www.bestcenter.mn)  
[www.collegeboard.org](http://www.collegeboard.org)  
[www.collegeconfidential.com](http://www.collegeconfidential.com)  
[www.sparknotes.com](http://www.sparknotes.com)  
[www.facebook.com/oyutniikhoolboo](http://www.facebook.com/oyutniikhoolboo)  
 Утас: 11 - 327733, 99084989, 95862888  
 9444 - AMSA, 9444 - BUOP, 9444 - BEST

Энэхүү өдөрлөг болон ВUOP хөтөлбөр нь Америкт тэтгэлэгтэйгээр оюуныхаа хүчээр суралцах боломж бололцоо болон мэдээллийг хүүхэд залуучуудад хүргэхэд чиглэгдсэн бөгөөд Америкийн аливаа нэгэн сургууль эсхүл байгууллагатай ажлын болон зуучлалын ямар ч холбоогүйгээс гадна цэвэр Америк дахь Монгол Оюутны Холбоо “Best” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж буй сайн дурын үйл ажиллагаа юм.